



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/345

Хэрлэн сум

Ид шидийн орон Хэнтий хүүхэд
хөгжил хамгааллын төв төслийг хэрэгжүүлэхэд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Хүүдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 340 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Иргэний нийгмийн байгууллагаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор Итгэл төгс нөмөр сан төрийн бус байгууллагаар Ид шидийн орон Хэнтий хүүхэд хөгжил хамгааллын төв төслийг хэрэгжүүлэх 2024 оны №2/20 дугаартай захиргааны гэрээний дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас ирүүлсэн дүгнэлт, мөнгөн дүнг үндэслэн хуваарийн дагуу 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ